| <b>8</b>    | <b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>                                    | <b>(1,043,319,200.00)</b> | <b>(998,622,358.61)</b> | <b>(44,696,841.39)</b> | <b>95.7</b> |

Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

|        |   |                  |                  |               |       |
|--------|---|------------------|------------------|---------------|-------|
| 9      | АЛДАГДЛЫГ<br>САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ<br>ҮҮСВЭР                  | 1,043,319,200.00 | 998,622,358.61   | 44,696,841.39 | 95.7  |
| 7      | Харилцах болон<br>хадгаламжийн дансны<br>цэвэр өөрчлөлт | 1,043,319,200.00 | 998,622,358.61   | 44,696,841.39 | 95.7  |
| 4      | Мөнгө, түүнтэй адилтгах<br>хөрөнгийн эхний үлдэгдэл     | -                | 1,046,453,670.99 |               |       |
| 5      | Мөнгө, түүнтэй адилтгах<br>хөрөнгийн эцсийн үлдэгдэл    | -                | 47,831,312.38    |               |       |
| 6      | ТӨСВИЙН БУСАД<br>МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ                     | 871              | 0                | 871           | -     |
| 61     | БАЙГУУЛЛАГЫН ТОО  | 1                | 1                | -             | -     |
| 610001 | Төсвийн байгууллага                                     | 1                | 1                | -             | -     |
| 62     | АЖИЛЛАГСДЫН ТОО   | 500              | 455              | 45            | 91.0  |
| 620001 | Удирдах ажилтан   | 1                | 1                | -             | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан                                       | 333              | 313              | 20            | 94.0  |
| 620003 | Үйлчлэх ажилтан   | 166              | 141              | 25            | 84.9  |

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага түүний үйл ажиллагаа

Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Эх нярай эмэгтэйчүүд хүүхдийн төрөлжсөн мэргэшлийн нотолгоонд суурилсан эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээг үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн ухаалаг технологи инновацыг дэмжин үзүүлэхэд оршино" гэж тодорхойлжээ.

Дээрх зорилтын хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд

- Нотолгоонд суурилсан анагаах ухааны ололтыг хэрэгжүүлэн дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх;
- Хүүхдийн мэс заслын шилдэг техник технологийг эмчилгээ оношилгоонд өргөн нэвтрүүлэх;
- Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ эх барихын тусламж үйлчилгээ сувилахуйн болон сэргээн засахын дагнасан тусламж үйлчилгээ шаардлагатай иргэнийг холбогдох эрүүл мэндийн байгууллагад илгээх эргэх холбоо тогтоох тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах;
- Ураг нярайн эрт оношилгооны үндэсний хэмжээний төв болох;
- Төрөлжсөн мэргэшлээр эмнэлгийн лавлагаа шатлалын мэргэшсэн тусламж үйлчилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх сургалт судалгаа эрдэм шинжилгээний ажил эрхлэх бусад эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил арга зүйгээр ханган ажиллах;

#### 3.2 Байгууллагын гадаад дотоод орчин

Тус төв нь Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын сангийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд үйл ажиллагаа санхүү нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт;
- Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт;
- Монгол улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 02-ний өдрийн 2 дугаар тогтоол "Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг тогтоох тухай";
- Эрүүл мэнд даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 01 сарын 23-ны өдрийн 04 дугаар тогтоолд орсон нэмэлт өөрчлөлт;
- Сангийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн Дугаар А/246 Тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг батлах тухай "Ерөнхий гэрээний аргаар эм эмнэлгийн хэрэглэгдэхүүн худалдан авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг";
- Сангийн сайдын 2025 оны 5 дугаар сарын 26-ны өдөр Дугаар А/103 "Тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг батлах" тухай тушаалууд нэмэлт өөрчлөлт болон шинээр батлагдсан байна.

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус төвийн Ерөнхий захирлын 2023 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн А/25 тушаалаар "Төвийн үйл ажиллагаанд дотоод аудит хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ыг баталж мөрдөн ажиллаж байна.

Дотоод аудит аудиторын чиг үүрэг түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус төвийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж нийтлэг зорилготой үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус төвийн Ерөнхий захирлын 2025 оны 09 дүгээр сарын 22-ний өдрийн Б/380а дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын "Журам шинэчлэн батлах тухай" 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант онд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тус төвийн жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,302,734.9 мянган төгрөгөөр буюу 9.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт                                     | Эхний үлдэгдэл      | Эцсийн үлдэгдэл     | Өөрчлөлт             |
|--|---------------------|---------------------|----------------------|
| Б  | 1                   | 2                   | 3=2-1                |
| Мөнгөн хөрөнгө                               | 1,053,626.7         | 47,831.3            | (1,005,795.4)        |
| Авлага                                       | 424,724.6           | 53,781.7            | (370,943.0)          |
| Бараа материал                               | 6,229,361.1         | 6,337,515.2         | 108,154.1            |
| Үндсэн хөрөнгө                               | 62,276,199.8        | 57,242,049.1        | (5,034,150.6)        |
| <b>Нийт хөрөнгө</b>                          | <b>69,983,912.2</b> | <b>63,681,177.3</b> | <b>(6,302,734.9)</b> |
| Өр төлбөр                                    | 684,368.1           | 2,749,727.7         | 2,065,359.7          |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/     | 69,299,544.1        | 6,093,1449.6        | (8,368,094.5)        |
| <b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b> | <b>69,983,912.2</b> | <b>63,681,177.3</b> | <b>(6,302,734.9)</b> |

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 47,831.3 мянган төгрөг болж 1,005,795.4 мянган төгрөгөөр буурсан нь эхний үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл 53,781.7 мянган төгрөг болж, 370,943.0 мянган төгрөгөөр буурсан нь Эрүүл мэндийн даатгалын сан болон байгууллагуудаас авах авлага барагдуулснаас шалтгаалсан байна.

Авлагын дансны үлдэгдэлд ТӨБЗГ-аас 200.0 мянган төгрөг, ЭМЯ-аас 6,540.0 мянган төгрөг, Моннис моторс ХХК 2,522.0 мянган төгрөг, Томобюлдинг ХХК 20,747.1 мянган төгрөг Хувь хүмүүсээс авах 21,183.1 мянган төгрөг, төлбөртэй үйлчилгээний авлага 2,589.5 мянган төгрөг, нийт 53,781.7 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байна.

Бараа материал дансны үлдэгдэл, 6,337,515.2 мянган төгрөгт хүрч, 108,154.1 мянган төгрөгөөр өсөхөд худалдан авсан 8,829,018.4 мянган төгрөг, ЭМЯ, ХӨСҮТ болон Төрийн бус байгууллага, хуулийн этгээдүүдээс вакцин, тариур, шприц, түлш шатахууны урамшуулал, хөнгөлөлт зэрэг 600,892.4 мянган төгрөгийн үнэ төлбөргүй бэлтгэсэн, 8,408,536.1 мянган төгрөгийг данс хооронд шилжүүлэн авсан, 10,152,993.4 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан, 7,416,704.9 мянган төгрөгийг данс хооронд шилжүүлсэн, 160,765.2 мянган төгрөгийн материалыг данс бүртгэлээс хассан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 57,242,049.1 мянган төгрөгт хүрч 5,034,150.6 мянган төгрөгөөр буурахад худалдан авсан 1,568,179.9 мянган төгрөг НҮБ-ын хүүхдийн сан, ГБХНХЯ, Прожект орбис интернэшнл ТББ-аас үнэ төлбөргүй шилжих ирсэн, 1,237,732.6 мянган төгрөг, шилжүүлэн авсан 295,755.4 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, данс хооронд шилжүүлсэн 195,118.5 мянган төгрөг, дахин үнэлсний зөрүү 467,442.4 мянган төгрөг, тайлант хугацаанд байгуулсан элэгдлийн зардал 7,473,257.7 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 2,749,727.7 мянган төгрөгт болж 2,065,359.7 мянган төгрөгөөр өсөхөд нийгмийн даатгалын шимтгэл, татварын өглөг 1,943,082.3 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс голлон шалтгаалсан байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэлд эм ханган нийлүүлэх байгууллагад өгөх өглөг 804,859.8 мянган төгрөг, татварын өглөг 1,230,119.9 мянган төгрөг, нийгмийн даатгалд өгөх өглөг 714,748.0 мянган төгрөгийн өглөг бүртгэлтэй байна.

Программ хангамжийн талаарх судалгааны үр дүн:

Тус төвд нийт 8 төрлийн 44,451.3 мянган төгрөгийн анхны өртөгтэй программ хангамж бүртгэлтэй, тайлант үед санхүүгийн программын хөгжүүлэлт тохиргооны хөлс 980.0 мянган төгрөг зарцуулсан байна. Тайлант хугацаанд 2 программ хангамж үлдэх өртөггүй байна. Хүснэгтээр харуулбал:

| № | Программын нэр       | Хэрэглэгч                            | Программын зориулалт               | Хөгжүүлэгч байгууллага                      |
|---|----------------------|--------------------------------------|------------------------------------|---|
| 1 | Karte.mn             | Эмч эмнэлгийн ажилчид                | Эмнэлгийн тусламж үйлчилгээ        | Аксис системс ХХК                           |
| 2 | Эмералд              | Санхүү нягтлан бодох бүртгэлийн алба | Санхүү бүртгэл                     | Интерактив Би Ай ХХК                        |
| 3 | Hinfo                | Статистик даатгалын алба             | Статистик дүр бүртгэл              | ЭМХТ  |
| 4 | Health.gov.mn        | Статистик даатгалын алба             | Эмч бүртгэл орлого нэхэмжлэх хянах | ЭМДЕГ                                       |
| 5 | Timely.mn            | Нийт эмнэлгийн ажилчид               | Цаг бүртгэл                        | Текстрим ХХК                                |
| 6 | Radiant Dicom viewer | Дүрс оношилгооны тасаг               | Зураг унших                        | Medixant нэртэй Польшийн компани хөгжүүлсэн |
| 7 | Microsoft office     | Нийт эмнэлгийн ажилчид               | Албан хэрэгцээ                     | Microsoft компани хийсэн бөгөөд хөгжүүлдэг. |

|   |               |                        |                |                                  |
|---|---------------|------------------------|----------------|----------------------------------|
| 8 | Adobe acrobat | Нийт эмнэлгийн ажилчид | Албан хэрэгцээ | Adobe Inc. компани боловсруулсан |
|---|---------------|------------------------|----------------|----------------------------------|

### 3.5 Төсвийн төлөвлөлт гүйцэтгэл нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх хэрэгжүүлэх тайлагнахад эрх бүхий байгууллага төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас 32,394,661.4 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,817,620.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 197,009.8 мянган төгрөг, нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 34,409,291.2 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас урсгал зардлыг 2,584,797.8 мянган төгрөгөөр бууруулж нийт зардлыг 31,824,493.4 мянган төгрөгөөр баталж, санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас 24,969,904.3 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 5,811,269.9 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 1,043,319.2 мянган төгрөг бүрдүүлэхээр баталжээ.

Төсвийг дахин тодотгож, нийт санхүүжүүлэх эх үүсвэрийг 810,281.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, эрүүл мэндийн даатгалын сангаас 28,326,270.9 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 3,256,184.3 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 1,043,319.2 мянган төгрөг бүрдүүлэхээр өөрчлөлт оруулж, нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 32,625,774.4 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээний санхүүжилтээс 27,139,597.6 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,526,567.5 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 994,926.6 мянган төгрөг, нийт 29,611,091.7 мянган төгрөгийн орлого, санхүүжилтийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 30,609,714.1 мянган төгрөг буюу 93.8 хувьтай байгаа нь батлагдсан төсвөөс цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардал 562,599.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний урсгал зардал 1,462,460.7 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулсан голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр арга хэмжээний төлөвлөгөө гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр арга хэмжээ |   | Төлөвлөгөө   | Гүйцэтгэл    | Зөрүү       | хувь  |
|-----|----------------------|---|--------------|--------------|-------------|-------|
|     | Код                  | Нэр                                       |              |              |             |       |
| 1   | 71602                | Эмнэлгийн тусламж үйлчилгээ               | 32,625,774.4 | 30,609,714.1 | 2,016,060.3 | 93.8  |
| 1.1 | 80101                | Үндсэн үйл ажиллагааны зардал             | 30,250,009.7 | 28,435,973.1 | 1,814,036.6 | 93.0  |
| 1.2 | 80802                | Ажил олгогчоос олгох тэтгэмж              | 144,312.8    | 144,312.8    | -           | 100.0 |
| 1.3 | 83601                | Нэмэлт - Олон улсын байгууллагаас олгосон | 80,456.3     | 80,456.3     | -           | 100.0 |
| 1.4 | 83603                | Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан   | 2,150,995.6  | 1,948,971.9  | 202,023.7   | 91.0  |

Батлагдсан төсөв гүйцэтгэл түүний хэтрэлт хэмнэлтийг орлого зардлын зүйл тус

бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

*1. Байгууллагуудын орон тооны цомхотголын талаар*

Тус төвийн ерөнхий захирлын 2025 оны 01 дүгээр сарын 03-ний өдөр “Төвийн төсөвт ор орон тоо ажилтнуудын албан тушаалын ангилал зэрэглэл батлах тухай” А/01 дугаар тушаалыг баталсан байна. Энэ тушаалын нэгдүгээр хавсралтаар орон тоог 500 ажилтантай баталж, гүйцэтгэлээр 457 ажилтан буюу 45 орон тоо дутуу ажиллаж байна.

*2. Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар:*

Унаа хоолны хөнгөлөлтийн зардлыг Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын ерөнхий захирлын 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/58 тоот тушаалаар өдрийн хоолны зардлыг 8.0 мянган төгрөг, унааны зардлыг өдрийн 3.0 мянган төгрөгөөр тогтоон мөрдөж байна. Тайлант хугацаанд 1,184,308.5 мянган төгрөгийг унаа, хоолны зардалд зарцуулсан байна.

*3. Гадаад томилолт, арга хэмжээний судалгааны үр дүн*

Гадаад албан томилолтын зардалд нийт 4 эмч 7,900.0 мянган төгрөг зарцуулсан бөгөөд эмчилгээ эрхэлсэн дэд захирал Өмнөд Африкийн Кейптаун хотод зохион байгуулагдсан “Дэлхийн эх барих эмэгтэйчүүдийн холбоо”-ны FIGO-25 хуралд илтгэл нь шалгаран хэлэлцүүлсэн байна. Мөн Оросын Холбооны Улсын Санкт Петербург хотноо “Эх хүүхдийн эндэгдлийг бууруулах” сэдэвт сургалтад 3 эмч 3,000.0 мянган төгрөг зарцуулан оролцсон байна.

*4. Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний судалгааны үр дүн:*

Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёр нь байгууллагуудтай хамтарсан болон эмнэлгийн дотоод сургалт хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардалд 42,002.6 мянган төгрөг зарцуулсан байна. Үүнд:

- Эрүүл Монгол Хүн-жирэмсний бүлгийн хяналт сургалт;
- Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Герман улсын мэс заслын төвтэй хамтарсан сургалт;
- Ажлын байран дахь хөдөлмөр аюулгүй байдлын сургалт;
- Резидент эмч нарын сургалт;
- Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлэг сургалт;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, Цацрагийн аюулгүй байдлын болон лабораторийн био аюулгүй байдал үнэлэх сургалт;
- Молекул биологийн шинжилгээний эмнэл зүйн хэрэглээ гэх мэт сургалтууд зохион байгуулан эмчилгээ үйлчилгээ эмнэл зүйн мэргэжлийн чадавхыг сайжруулан өвчний сэргийлэлт, мэдлэг мэдээлэл хяналтыг сайжруулсан байна.

Хэвлэлийн дуу хоолой нийгэмд үйлчилдэг ТББ -аас ажил гүйцэтгэх гэрээг байгуулан мэдээлэл үйлчилгээний зардлаас 8,000.0 мянган төгрөгөөр эрүүл мэндийн тусламж үйлчилгээний танилцуулга хийлгэн мэдээлэл сурталчилгаанд зарцуулсан байна.

#### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 14,725,169.5 мянган төгрөгийн 22 багц бараа ажил үйлчилгээ худалдан авахаар төлөвлөж баталсан байна. Үүнээс 13,952,601.5 мянган төгрөгийн 12 багц бараа ажил үйлчилгээг нээлттэй тендер шалгаруулалтаар, 731,568.0 мянган төгрөгийн 8 багц бараа ажил үйлчилгээг харьцуулалтын аргаар, 41,000.0 мянган төгрөгийн бараа, зөвлөх үйлчилгээг ерөнхий гэрээгээр худалдан авахаар төлөвлөгөөнд тусгажээ.

Гүйцэтгэлээр эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, хоол хүнс, бичиг хэрэг, багаж техник хэрэгсэл, эмнэлгийн зөөлөн эдлэл, тоног төхөөрөмжийн урсгал засвар болон бусдаар гүйцэтгүүлэх үйлчилгээнд 10,133,603.2 мянган төгрөг, тээвэр шатахуун, шуудан холбоо, хог хаягдал, хөдөлмөр хамгаалал, мэдээлэл технологийн үйлчилгээ хангамж, аж ахуйн материалд, 247,095.1 мянган төгрөг, зөвлөх үйлчилгээнд 16,500.0 мянган төгрөг, нийт 10,397,198.3 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага түүний орчин аудитад хамааралтай дотоод хяналт нягтлан бодох бүртгэл санхүүгийн тайлагналын үзэл баримтлал аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл түүнийг шийдвэрлэсэн байдал дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах анхан шатны баримтын бүрдлийг хангуулах, цалин хөлс, шагнал урамшууллыг зөв тооцож олгох, шатахуун тооцоог нормын дагуу бодож байх, үндсэн хөрөнгийн элэгдлийг зардлын зөв тооцох, бараа материалын дансыг зөв ангилан бүртгэх асуудлыг шийдвэрлүүлэх өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай аудит” ХХК-ийн ахлах аудитор С.Батжаргал туслах аудитор Д.Оюунцэцэг нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Ж.Бямбажав дараагийн шатны хяналтыг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер В.Эрдэнэцогт, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын 2025 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлийг Дундманхайдай аудит ХХК-д 2026 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01-1/31 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 37,700,571.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 377,005.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тайлант онд батлагдсан төсвөөс цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардал 562,599.6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 66,067.7 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 37,280.4 мянган төгрөг, норматив зардал 1,018,937.3 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 123,945.8 мянган төгрөг томилолт зочны зардал 2,750.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж, урсгал шилжүүлгийн зардал 213,479.5 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулсан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 3,022,677.5 мянган төгрөгийн зөрчлөөс 3,022,677.5 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд "Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ" болон "Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил үйлчилгээ"-г мөнгөн хөрөнгийн дансны журнал харилцах дансны хуулгатай тулгахад 3,022,677.5 мянган төгрөгийн 497 гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан байна. Мөн худалдан авалтын төлөвлөгөөг хугацаа хоцроон байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх" 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.13.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр гүйлгээний агуулга хүлээн авагчийн нэр" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, цахим системд мэдээллийг хуулийн хугацаанд нь мэдээлж байх зөвлөмж өгөв.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 улирлын санхүүгийн тайланг хамруулж авлага, мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, орлогын данстын хувьд горим сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулан асуудлын бүртгэлээр баталгаажуулж, 1,311,299.8 мянган төгрөгийн 7 алдааг залруулсан.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4,320.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 594,704.5 мянган төгрөгийн 6 албан шаардлага, 7,679.3 мянган төгрөгийн 5 зөвлөмж өгсөн нь 100 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт          | Өмнөх аудитын үзүүлэлт |                  | Биелэлт   |                  |              |
|-------------------|------------------------|------------------|-----------|------------------|--------------|
|                   | Тоо                    | Дүн              | Тоо       | Дүн              | Хувь         |
| Акт               | 1                      | 4,320.0          | 1         | 4,320.0          | 100.0        |
| Албан шаардлага   | 6                      | 594,704.5        | 6         | 594,704.5        | 100.0        |
| Зөвлөмж           | 5                      | 7,679.4          | 5         | 7,679.4          | 100.0        |
| Хариуцлага тооцох | 1                      | 37,336.6         | 1         | 37,336.6         | 100.0        |
| <b>Нийт дүн</b>   | <b>11</b>              | <b>644,060.5</b> | <b>11</b> | <b>644,060.5</b> | <b>100.0</b> |

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал:

1. Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан журмын дагуу нягтлан бодох бүртгэлийн программ хангамжид санхүүгийн тайлангийн маягтыг шинэчлэх;
2. Цалин хөлс, илүү цаг, нэмэгдэл урамшлын тооцоолол олголт болон шатахууны зарцуулалтын гүйцэтгэлд давтан тооцоолол хийж хяналтыг хэрэгжүүлэхэд дараагийн аудитаар анхаарлаа хандуулах шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,311,299.8 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 1,311,299.8 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайланд төлбөртэй үйлчилгээний авлагыг 196,874.6 мянган төгрөгөөр илүү тайлагнасан;
- Мөнгөн гүйлгээний тайланд жижиг мөнгөн сангийн дансны эцсийн үлдэгдлийг 18.8 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн;
- Мөнгөн хөрөнгийн дансанд 1,073,600.2 мянган төгрөгийн орлогын гүйлгээг давхардуулан бүртгэсэн;
- Бараа материалын дэлгэрэнгүй тайлангийн эхний болон эцсийн үлдэгдлийг 1,647.9 мянган төгрөгөөр бараа материалын тодруулга тайланд зөрүүтэй тайлагнасан;
- Орлого үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийг 25,783.9 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Орлого үр дүнгийн тайланд элэгдэл хорогдлын зардлыг 8,524.9 мянган төгрөгөөр илүү тайлагнасан;
- Архивын ерөнхий газар болон Зэвсэгт хүчний 303-р ангийн 4,849.4 мянган төгрөгийн цахилгааны төлбөрийг үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн

Энэ нь УСНББОУС-1-ийн 27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдлуудыг үзэл баримтлалд заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг" гэсэнтэй нийцээгүй, санхүүгийн тайлагналын толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй.

Аудитаар нийт 289,652.4 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд 11,609.7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 94,278.5 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 183,764.2 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа зөрчлөөс 289,652.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 87,353.3 мянган төгрөгөөр бага тул "Өөрчлөлтгүй дүгнэлт" өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

1. Сахилгын шийтгэлтэй албан хаагчид сахилгын шийтгэлтэй байх хугацаанд 810.2 мянган төгрөгийн улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8-д "Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 2.7-д "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй", Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын ерөнхий захирлын 2022 оны А/58 дугаар

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

"Хөдөлмөрийн дотоод журам шинэчлэн батлах тухай" тушаалын 14 дүгээр зүйлийн 14.3.8-д "Сахилгын шийтгэлийн хугацаа дуусаагүй ажилтанд шагнал урамшуулал олгохгүй" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомжийн дагуу сахилгын албан тушаалтанд үр дүнгийн урамшуулал олгосныг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Ээлжийн амралтын цалин бодолтоос түүвэрлэн давтан тооцоолоход зарим ажилтны амралтын нөхөн олговор, цалин хөлсийг 953.6 мянган төгрөгөөр давхардуулан олгосон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-т "ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно", 110 дугаар зүйлийн 110.2-т "ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд ээлжийн амралтын цалинг нэг аравны тав дахин нэмэгдүүлж олгоно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг авлага ба төлбөрийн тооцоог хянах ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ээлжийн амралтын нөхөн олговор, цалин хөлс давхардуулан олгосон зөрчлийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3. Төвийн ерөнхий захирлын 2025 оны Б/482 дугаар тушаалаар сахилгын 2 сарын хугацаагаар үндсэн цалинг 20 хувь бууруулах шийтгэлийг 406.8 мянган төгрөгөөр дутуу суутгасан байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8-д "Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын шийтгэлийг дутуу суутгасан зөрчлийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

4. Ажлаас чөлөөлөгдсөн 2 албан тушаалтантай ээлжийн амралтын эцсийн тооцоо хийгээгүйгээс 3,119.1 мянган төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт журам заавар энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж санхүүгийн тайлан гаргах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ээлжийн амралтын эцсийн тооцоо хийгээгүйгээс илүү олгосон цалинг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5. Тайлант хугацааны шатахуун зарцуулалтын тайланг шалгахад Замын хуудсаар тооцоог бодоогүй анхан шатны баримтгүй 2,349.3 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна. Энэ нь Монгол улсын Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны САГ-2026/362/НА-СТА-ТШЗ

390 дугаар тушаал "Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Замын хуудсыг гарын үсэг зурж баталгаажуулаагүй анхан шатны баримтгүй шатахуун зарцуулсныг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

6. Эмнэлгийн ажилчдын баяраар 396 ажилчдад урамшуулалд олгосон 39,700.0 мянган төгрөгөөс хувь хүний орлогын албан татварт 10 хувийг суутгасан боловч холбогдох татварын албанд 3,970.0 мянган төгрөгийг шилжүүлэх үүргээ биелүүлээгүй өглөгтэй байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын 6 дугаар зүйлийн 6.3-д "Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно: 6.3.5-д "шууд бус орлого", 25.1.1-д "энэ хуулийн 14 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж холбогдох төсөвт шилжүүлэх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж шагнал урамшуулал дэмжлэг олгох" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Суутган тооцсон хувь хүний орлогын албан татварыг төсөвт төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

## 5.2 Албан шаардлага

1. Хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллаж байгаа албан хаагчдад гэрээнд тусгаагүй мэргэшлийн зэргийн нэмэгдэл, онцгой нөхцөлийн нэмэгдэл, улирлын ажлын мөнгөн урамшуулал олгож, нийт 11,546.3 мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж шагнал урамшуулал дэмжлэг олгох" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллаж байгаа албан хаагчдад гэрээнд тусгагдаагүй нэмэгдэл, урамшуулал олгосон зөрчлийг таслан таслах зогсоох, албан шаардлага хүргүүлэв.

2. Ижил төрлийн бараа материалыг худалдан авах ажиллагааны тендерт шалгарсан компаниас худалдан аваалгүй Медиконт Аялуун, Монфа трейд, Чин баян трединг ХХК-аас 8,701.0 мянган төгрөгийн шууд гэрээ байгуулан худалдан авсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө", 46.1.5-д энэ хуулийн 7.6-д "зааснаас бусад бараа ажил үйлчилгээг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр батлагдсаны дараа худалдан авах ажиллагааг эхлүүлэх", 46.1.6-д "гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ижил төрлийн бараа материалыг тендерт шалгарсан компаниас худалдан авалгүй, өөр компаниас шууд худалдан авах гэрээ байгуулан авсан зөрчлийг таслан зогсоох, албан шаардлагыг хүргүүлэв.

3. Ерөнхий захирлын 2025 оны Б/540, Б/541 дүгээр тушаалаар 2025 оны шилдэг ажилтан алба нэгжийг шагнахдаа Хөдөлмөрийн дотоод журамд зааснаас илүү 10,000.0 мянган төгрөгийн шагнал олгосон байна. Энэ нь Эх, нярай, эмэгтэйчүүдийн

үндэсний төв хоёрын Ерөнхий захирлын 2022 оны 04 сарын 15-ны өдрийн А/58 дугаар тушаалаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 14.3.2.17-д "Онцгой нөхцөл байдал гамшгийн үед онцгой үүрэг гүйцэтгэсэн ажилтанд Ерөнхий захирлын нэрэмжит 1,000,000.00 төгрөгийн урамшуулал олгоно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөдөлмөрийн дотоод журамд зааснаас илүү шагнал олгосон зөрчлийг таслах зогсоох, албан шаардлагыг хүргүүлэв.

4. Тайлант хугацаанд тус байгууллагын ажилчдад илүү цагийн нэмэгдэл хөлс олгохдоо Засгийн газрын 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад нэмэгдэл хөлс олгох журам"-д заасан тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрүүлэн 248 цагийн нийт 18,047.9 мянган төгрөгийг олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад нэмэгдэл хөлс олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3-т "Илүү цагаар долоо хоногийн амралтын өдрөөр нийтээр амрах баяр ёслолын өдрөөр шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад нэмэгдэл хөлс олгох журам мөрдөөгүй зөрчлийг таслах зогсоох, албан шаардлагыг хүргүүлэв

5. Бараа материалын дансанд 10 нэр төрлийн 25,236.1 мянган төгрөгийн хангамж хэрэгсэл ариутгалын бодис он дамжсан үлдэгдэлтэй зарцуулалт гараагүй хэрэгцээ шаардлагагүй нөөц үүсэх эрсдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа материал бэлтгэх нөөцлөх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Он дамжсан үлдэгдэлтэй зарцуулалт гараагүй хэрэгцээ шаардлагагүй нөөц үүсэн зөрчлийг таслах зогсоох, албан шаардлагыг хүргүүлэв.

6. Өмнөх онд үүссэн 20,747.2 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, барагдуулаагүй байна. Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг авлага ба төлбөрийн тооцоог хянах ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах", 15.2.5-д "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Он дамжсан авлагын үлдэгдлийг баталгаажуулж, барагдуулаагүй зөрчлийг таслах зогсоох, албан шаардлагыг хүргүүлэв.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1.Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

### 1.1 Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 49 нэр төрлийн 248,502.3 мянган төгрөгийн хөрөнгийг холбогдох эрх бүхий байгууллагад санал хүргүүлж ашиглалтыг сайжруулах талаар арга хэмжээ аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.5 “хэмжигдэхүйц байх”, ТБОНӨ-ийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-т “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дугаар тушаалын 7.1-д “Элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэсэн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийн цаашид ашиглах хугацаа шинэчлэн тогтоох үнийн саналыг боловсруулж Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хандан шийдвэрлүүлэх.

### 1.2 Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй гаднын байгууллагад шилжсэн 2 тээврийн хэрэгслийн тайлант үеийн 86,920.6 мянган төгрөгийн элэгдлийг зардлыг тооцож бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх санхүүгийн тайлан мэдээллийн үнэн зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2025 оны 1 дүгээр сарын 3-ний өдрийн АЗ дугаар тушаалын хавсралтын 10.19-д “Элэгдэл нь хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглалтын хугацаанд хуваарилах системтэй хуваарилалт юм” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна. ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 8 дугаар зүйлийн 8.6-д “Тээврийн хэрэгслийг акталж данснаас хасах тухай шийдвэрийн биелэлтийг ирүүлэхдээ Авто тээврийн үндэсний төвөөс авто тээврийн хэрэгслийн улсын бүртгэл болон татвар төлөгчийн бүртгэлээс хассан тухай лавлагааг ирүүлнэ” гэсэн заалттай тус тус нийцэхгүй санхүүгийн тайлангийн “оршин байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Авто тээврийн хэрэгслийн хадгалалт ашиглалтын байдалд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж ТӨБЗГ-т хандаж шийдвэрлүүлэх арга хэмжээг авах.

### 1.3 Илрүүлэлт:

Газар зохион байгуулалт геодези зураг зүйн ерөнхий газраас газрын мэдээллийн лавлагааг авч санхүүгийн тайлан үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлтэй тулган шалгахад 82,000.0 мянган төгрөг буюу 10,000 м.кв газар, газрын кадастрын нэгдсэн системд бүртгэлгүй байна. Энэ нь Газрын тухай хуулийн 34 дүгээр зүйл Газар эзэмших гэрээ түүнийг байгуулах журмын 34.5-д “Улсын бүртгэлд эрхийн гэрчилгээг олгосон он сар өдөр эзэмшигчийн нэр олгогдсон газрын нэгж талбарын дугаар хэмжээ байршлыг тэмдэглэх бөгөөд эрхийн гэрчилгээтэй холбогдсон аливаа өөрчлөлтийг тусгах зориулалт бүхий хавсралттай байна” гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Газрын кадастрын нэгдсэн системд бүртгэлгүй газрын гэрээ гэрчилгээг гаргуулах асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэн зөв ангилан бүртгэх.

## **2. Бараа материалын данстай холбоотой асуудал**

### **2.1 Илрүүлэлт:**

Үндсэн хөрөнгийн шинжтэй 14,843.6 мянган төгрөгийн 306 ширхэг ширээ сандлыг бараа материалын дансанд бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт журам заавар энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж санхүүгийн тайлан гаргах" гэж тус тус заасантай нийцээгүй;

### **Өгсөн зөвлөмж:**

Бараа материалын дансанд буруу ангилан бүртгэсэн хөрөнгийг ТӨБЗГ-т санал хүргүүлж шийдвэрлүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТАР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

| № | Алдааны товч утга  | Нийт алдаа |                    | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |          | Буруу тусган илэрхийлсэн |                    | Үүнээс   |                    |          |          | Зөвлөмж  |          |
|---|--|------------|--------------------|-----------------------------------|----------|--------------------------|--------------------|----------|--------------------|----------|----------|----------|----------|
|   |  | Тоо        | Дүн                | Тоо                               | Дүн      | Тоо                      | Дүн                | Тоо      | Дүн                | Тоо      | Дүн      | Тоо      | Дүн      |
| 1 | Санхүүгийн байдлын тайланд төлбөртэй үйлчилгээний авлагыг 196,874.6 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна.   | 1          | 196,874.6          | -                                 | -        | 1                        | 196,874.6          | 1        | 196,874.6          | -        | -        | -        | -        |
| 2 | Мөнгөн гүйлгээний тайланд жижиг мөнгөн сангийн дансны эцсийн үлдэгдлийг 18.8 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн байна                                 | 1          | 18.8               | -                                 | -        | 1                        | 18.8               | 1        | 18.8               | -        | -        | -        | -        |
| 3 | Мөнгөн хөрөнгийн дансанд 1,073,600.2 мянган төгрөгийн орлогын гүйлгээг давхардуулан бүртгэсэн байна.   | 1          | 1,073,600.2        | -                                 | -        | 1                        | 1,073,600.2        | 1        | 1,073,600.2        | -        | -        | -        | -        |
| 4 | Бараа материалын дэлгэрэнгүй тайлангийн эхний болон эцсийн үлдэгдлийг 1,647.9 мянган төгрөгөөр бараа материалын тодруулга тайланд зөрүүтэй тайлагнасан | 1          | 1,647.9            | -                                 | -        | 1                        | 1,647.9            | 1        | 1,647.9            | -        | -        | -        | -        |
| 5 | Орлого үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийг 25,783.9 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан                                      | 1          | 25,783.9           | -                                 | -        | 1                        | 25,783.9           | 1        | 25,783.9           | -        | -        | -        | -        |
